



СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

᠒᠐23 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 4/29

Улаанбаатар хот

Цэвэрлэгээ халдваргүйтгэлийн журам

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль 3 зүйл 3.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS6392:2013 стандарт 7.1 заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн “Цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх ерөнхий зарчим”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Үйлчлэгч нарын цэвэрлэгээний ажлын норм”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Цэвэрлэгээ, байнгын халдваргүйтгэлийн бодисын тооцоолол хэрэглээ, ашиглалт”-ыг гуравдугаар хавсралтаар, “Цэвэрлэгээ халдваргүйтгэлийн хяналт үнэлгээг” дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү журмын биелэлтийг хэрэгжүүлж ажиллахыг тасаг, нэгжийн эрхлэгч, албадын дарга нарт даалгасугай.

3. Тус үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Халдварын сэргийлэлт хяналт, дархлаажуулалтын албаны дарга (А.Дэлгэрбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү журмын үйл ажиллагаанд зарцуулагдах санхүүгийн асуудлыг шийдвэрлэхийг Санхүүгийн албаны дарга (Ж.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд эрхэлсэн дэд захирал (Б. Баяндалай)-д даалгасугай

ЗАХИРАЛ



Ц.ОЛОНБАЯР